

# МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

## Ангилалтын код 13.080.10

Усны чанар. Тайлбар толь

Water quality. Vocabulary

MNS ISO 6107-1:2002

Стандартчилал, хэмжилзүйн үндэсний төвийн зөвлөлийн 2002 оны 05 дугаар сарын 30-ний өдрийн 22 дугаар тогтоолоор батлав.

Энэ стандарт нь 2002 оны 06 дугаар сарын 01 өдрөөс эхлэн хүчинтэй.

Энэхүү стандартын шаардлагыг заавал мөрдөнө.

### 1. Оршил

Энэ нэр томъёоны тайлбар тольд өгөгдсөн тодорхойлолтууд нь усны чанарын нэр томъёог стандартчилахад зориулагдсан. Энэ тольд орсон нэр томъёо нь олон улсын өөр бусад байгууллагаас эрхлэн хэвлүүлсэн тайлбар тольд орсон нэр томъёотой ижил утгатай. Гэхдээ тодорхойлолтуудыг хэрэглэх зорилго нь өөр өөр байсантай холбоотойгоор энэ тайлбар толиныхоос арай өөр байж болно.

### 2. Хэрэглэх хүрээ

ISO 6107-ийн 1-р хэсэгт усны чанарыг илэрхийлэх нэр томъёонууд орсон.

Нэр томъёо, тодорхойлолтуудыг дор дурдсан үндсэн гол чиглэлээр бүлэглэн ангилж өгөв.

Үүнд:

1. Усны төрөлд хамаарах нэр томъёо
2. Ус цэвэршүүлэлт, хадгалалт болон хаягдал устай холбоотой нэр томъёо

### 3. Норматив ишлэл

Дор дурдсан стандартуудын зарим заалтыг ISO 6107-ын I хэсгийн дотор иш татаж оруулав.

Энэхүү ISO 6107-ын I хэсгийн хэвлэн гаргах үед эдгээр стандартууд нь хүчин төгөлдөр үйлчилж байгаа болно. Ямар ч стандартыг өөрчлөн шинэчилж болно.

ISO 6107 тоот стандартын энэ хэсэгт өөрчлөлт оруулах шийдвэр гаргах талууд дор бичигдсэн стандартуудын хамгийн сүүлийн үед шинэчилсэн хувилбарыг ашиглах хэрэгтэй.

IEC ба ISO-ийн гишүүн улсуудад хүчин төгөлдөр хэрэглэгдэж байгаа стандартуудын жагсаалт байдаг билээ.

MNS ISO 6107-2:2000 Усны чанар- Тайлбар толь – 2-р хэсэг.

MNS ISO 6107-3:2000 Усны чанар- Тайлбар толь – 3-р хэсэг.

MNS ISO 6107-8:2000 Усны чанар- Тайлбар толь – 8-р хэсэг.

## **MNS ISO 6107-1 :2002**

### **1. Усны төрөлд хамаарах нэр томъёо**

#### **1.1. Түүхий ус**

##### **1.1.1. Эпилимион**

Усан орчинд температурын зөрөөнөөс болоодүүссэн үе давхаргуудын хамгийн их температур бүхий давхаргаас дээш орших ус.

##### **1.1.2. Эвтроф ус**

Усны төрлийн боловч харьцангуй их тоо хэмжээтэй бичил биетэнүүдийг агуулсан биологийн гаралтай тэжээлийн бодисуудаар баялаг ус. (ISO 6107-2-ийг үз. Эвтрофикаци)

##### **1.1.3. Газрын доорх ус**

хөрсөнд агуулагдсан бөгөөд түүнээс авч хэрэглэх боломжтой ус.

##### **1.1.4. Гипертроф ус**

энэ нь эвтроф усны нэг төрөл (эвтроф ус гэснийг үз 1.1.2) бөгөөд замаг зэрэг биологийн гаралтай, элбэг тохиолддог бодисоор баялаг ус.

##### **1.1.5. Гиполимион**

Усан орчинд температурын зөрөөнөөс болж үүсдэг үе давхаргуудын хамгийн бага температур бүхий давхаргаас доош орших ус.

##### **1.1.6. Олиготроф ус**

Биологийн гаралтай тэжээлийн бодисоор ядуувтар бөгөөд тунгалаг, дээд үе давхарга нь хүчилтөрөгчээр арвин, усанд байдаг амьд биетэн цөөн голчлон хүрэн бор өнгөтэй цөөн тооны органик бодис бүхий ус.

##### **1.1.7. Полисапроб ус**

Хүчилтөрөгчийн ихээхэн хэмжээний дутагдалд орсон, сээр нуруугүй амьтны тоо их багасч, нянгийн тоо ихээхэн өсч, гойд их бохирдсон ус. (ISO 6107-8-ийг үз., мезосапроб)

##### **1.1.8. Борооны ус**

Хур тундаснаас үүссэн хөрсөн дэхь уусдаг бодис хараахан нэвчин орж ирээгүй байгаа ус.

##### **1.1.9. Боловсруулалт хийгдээгүй ус**

энэ нь ямар нэгэн боловсруулалтанд ороогүй цэвэршүүлэлтээс станцид орж ирж буй, эсвэл нэмэлт боловсруулалт хийх шаардлагатай ус.

##### **1.1.10. Аадар борооны ус**

Хүчтэй аадар борооны улмаас үүсэн урсаж буй гадаргуугийн ус.

##### **1.1.11. Аадар борооны урсац**

Хотын гудамж талбайн илүүдэл урсац болон аадар борооны ус буюу цас мөс хайлснаас үүсэх их ус холилдсон урсац.

##### **1.1.12. Үе давхарга үүсэх**

температур, давс, хүчилтөрөгчийн агууламж болон биологийн гаралтай тэжээлийн бодисуудын агууламжаас шалтгаалан усны дотор үе давхарга үүсж буй болох үзэгдэл.

**1.1.13. Гадаргуугийн ус**

газрын гадаргуу дээр тунах буюу гадаргуугаар урсаж буй ус.

**1.1.14. Термоклин**

Температурын ялгавраар усанд үүсэх үе давхаргуудын хамгийн их температур бүхий үе давхарга.

**1.2. Хаягдал ус**

**1.2.1. Ёроолын хагшаас**

Хөрсний эвдрэл ба биологийн үйл ажиллагаагийн үр дүнд эсвэл хаягдал усны зайлуулалтаас гол мөрөн, нуур, тэнгисийн ёроолын хуримтлагдан үүсэх органик бодисууд.

**1.2.2. Детрит**

биологийн талаас нь авч үзвэл энэ нь үхсэн амьд амьтан ба органик бодисын жижиг хэсгүүд юм. Тэдгээр нь гол, нуурын ёроолд хуримтлагдсан ба хөвсөн байдалтай байж болно. Хаягдал усыг цэвэршүүлэх утгаар нь усны урсгалаар тээвэрлэгддэг, органик бодистой холбогдсон том хэмжээний органик бус бодисууд.

**1.2.3. Хаягдал**

Ус цэвэршүүлэх байгууламж, үйлдвэрийн газар эсвэл тунгаагуураас зайлуулж байгаа ус ба хаягдал ус.

**1.2.4. Үйлдвэрлэлийн хаягдал ус**

Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа ашигласны эцэст зайлуулагдаж байгаа ус, ойрын ирээдүйд үйлдвэрлэлд дахин ашиглагдахгүй ус.

**1.2.5. Ахуйн хаягдал бохир ус**

Хүн ам суурьшсан газраас хаягдаж байгаа ус.

**1.2.5.1. Хот суурингийн цэвэршүүлэлт хийгээгүй ус**

Хот газрын цэвэршүүлэлт хийгдээгүй хаягдал ус.

**1.2.5.2. Цэвэршүүлэгдсэн хаягдал бохир ус**

Агуулагдаж байгаа эрдэс бодис ба органик бодисоос нь цэвэрлэх зорилгоор бүрэн буюу цэвэршүүлэлт хийсэн хот суурингийн хаягдал бохир ус.

**1.2.5.3. Хотын хаягдал усыг зайлуулах**

Хот суурингийн хаягдал бохир усыг цэвэрлэх байгууламжид цэвэршүүлсний дараа зайлуулах.

**1.2.6. Лаг (шавар)**

Усанд агуулагдан тунаж, ёроолд тунадасждаг хатуу бодисуудыг байгалийн болон зохиомол аргын тусламжтайгаар уснаас салган авсан хуримтлал (meu;gv)

## **MNS ISO 6107-1 :2002**

### **1.2.6.1. Идэвхит лаг**

Хаягдал усыг цэвэршүүлэх явцад усанд ууссан хүчилтөрөгчтэй нөхцөлд бактериуд болон бичил биетэнгийн өсөлтийн үр дүнд үүссэн биомасс. (флокжуулсан тунадас).

### **1.3. Ундны ус**

#### **1.3.1. Ундны ус**

чанарын хувьд хүн амын унданд хэрэглэж болох ус.

#### **1.3.2. Усан хангамжийн зориулалттай ус**

Цэвэршүүлэх байгууламжид цэвэршүүлсний дараа ус түгээх систем буюу ус хадгалах санд (усны ган) өгөгдөж байгаа ус.

### **1.4. Үйлдвэрийн технологийн зориулалттай ус**

#### **1.4.1. Үйлдвэрлэлийн ус**

үйлдвэрийн үйл ажиллагаанд хэрэглэж байгаа ус.

#### **1.4.2. Бойлерын ус**

Бойлерт ус буцлах үед эсвэл түүгээр дамжин өнгөрч байгаа тодорхой шинж чанарыг агуулсан ус.

#### **1.4.3. Хөргөлтийн ус**

дулаан шингээх болон дулаан дамжуулах зорилгоор хэрэглэж байгаа ус.

### **1.5. Усны чанартай холбоотой нэр томъёо**

#### **1.5.1. Усны чанарын үнэлгээний үзүүлэлтүүд**

Ашиглалтын тухайн зорилгоор тавигдаж байгаа шаардлагуудыг хангаж байгаа эсэхэд үнэлгээ өгөхөд хэрэглэх усны чанарыг илэрхийлэгч үзүүлэлтүүдийн цогц.

#### **1.5.2. Усны чанарын стандарт**

янз бүрийн зориулалтаар ус ашиглах усны чанарын үзүүлэлтүүдийн зөвшөөрөгдөх агууламж.

## **2. Ус цэвэршүүлэлт, хадгалалт болон хаягдал устай холбоотой нэр томъёо**

### **2.1. Идэвхит лагаар цэвэршүүлэх**

Үүнд хаягдал ус ба идэвхит лаг хоёрыг холихдоо агааржуулах замаар хаягдал усыг биологийн аргаар цэвэршүүлэх үйл ажиллагаа (идэвхитэй лаг 1.2.6.1.)

ТАЙЛБАР: усыг цэвэршүүлсний дараа идэвхит лагийг тунгаах аргаар уснаас нь салгана. Шаардлагатай бол түүнийг зайлуулах, буюу ус цэвэршүүлэх үйл ажиллагаа буцааж оруулна.

### **2.2. Химийн аргаар усыг цэвэршүүлэх**

шаардлагатайүр дүнд хүрэх зорилгоор химийн бодис нэмж өгөх замаар ус цэвэршүүлэх үйл ажиллагаа.

### **2.3. Физик-химийн боловсруулалт**

шаардлагатай үр дүнд хүрэх зорилгоор физик, химийн боловсруулалтыг хамтатган хэрэглэхийг хэлнэ.

**2.4. Агааржуулалт**

шингэн агаар оруулах үйл ажиллагаа.

**2.5. Агааржуулсан төлөв байдал**

Усанд ууссан хүчилтөрөгч байх тэрхүү төлөв байдал.

**2.6. Агааргүй төлөв байдал**

усанд ууссан хүчилтөрөгч, нитрат, нитрит бодис байхгүй төлөв байдал.

**2.7. Ферментэт үе давхарга**

биологийн шүүлтүүрийг үз (2.8)

**2.8. Биологийн шүүлтүүр**

том нүх сүвтэй идэвхигүй материалын үе давхарга дундуур хаягдал усыг нэвтрүүлэх замаар усыг цэвэршүүлэх үйл ажиллагаа. Гэхдээ идэвхигүй материал нь биологийн хувьд идэвхитэй нимгэн хальсаар хучигдсан байна.

**2.9. Химийн коагуляци**

Усан дахь коллоид жижиг хэсгүүдийн тогтвортой байдлыг эвдэж сарниулан улмаар нэвсгэр тунадас үүсгэх зорилгоор химийн бодис (коагулянт) нэмж, коллоид жижиг хэсгүүдийг үүсгэх үйл ажиллагаа.

**2.10. Агааргүйжүүлэлт**

Усанд ууссан агаарыг байгалийн болон физикийн үйлчлэлээр зайлуулах үйл ажиллагаа.

**2.11. Хлоргүйжүүлэлт**

химийн эсвэл физикийн аргаар усан дахь үлдэгдэл хлорыг бүрэн эсвэл тодорхой хэмжээгээр зайлуулах үйл ажиллагаа.

**2.12. Хийгүйжүүлэлт**

усанд ууссан хийн байдалтай бодисыг тодорхой хэмжээгээр буюу бүрэн гүйцэд зайлуулах үйл ажиллагаа. Голчлон физикийн аргуудыг ашигладаг.

**2.13. Ионгүйжүүлэлт**

Усанд байгаа ионуудыг тодорхой хэмжээгээр буюу бараг бүрэн зайлуулах үйл ажиллагаа бөгөөд үүнд голчлон ионсолилцлын давирхайнуудыг ашигладаг. (2.14 ба 2.17-г үз)

**2.14. Эрдэсжүүлэлт**

физик, химийн буюу биологийн үйл ажиллагааийг ашиглан усанд ууссан органик бус нэгдлүүд ба ионы бүлгүүдийн агууламжийг багасгах үйл ажиллагаа. (2.13 ба 2.17-г үз)

**2.15. Нитратгүйжүүлэлт**

Нитрат, нитратийн агуулгыг багасгах буюу азот буюу азотын оксид(II)-ын хэмжээг багасгах үйл ажиллагааг хэлэх бөгөөд голчлон бактериар үйлчлэх аргыг хэрэглэдэг.

**2.16. Хүчилтөрөгчийг зайлуулах**

усанд ууссан хүчилтөрөгчийг тодорхой хэмжээгээр буюу бүрэн зайлуулах. Үүний тулд байгалийн жамаар нь эсвэл байлгах эсвэл физик химийн аргыг хэрэглэнэ.

**2.17. Давсгүйжүүлэх**

усыг ундны, технологийн ба ус хөргөх зориулалтаар боломжтой болгохын тулд ашиглах усанд байгаа ионуудыг тодорхой хэмжээгээр эсвэл бүрэн зайлуулах.

**2.18. халдваргүйжүүлэх**

халдварт өвчин тараадаг бичил биетнийг устгах идэвхийг нь бууруулах зорилгоор усыг боловсруулалтад оруулах.

**2.19. Нэрэлт**

усыг дээд зэргээр цэвэршүүлэхийн тулд түүнийг нэрж дараа нь конденсацад оруулах.

**2.20. Цахилгаан шинжилгээ**

цахилгаан орны үйлчлэлийн нөлөөгөөр тодорхой төрлийн ион нэвтрүүлэх чадвартай хагас дамжуулагч мембран дундуур усны нэг хэсгээс (орон зайн) нөгөө орон зайд шилжүүлэхэд ионууд нь усны нэг хэсгээс салж, нөгөөтэй нэгдэнэ. Энэ үйл ажиллагааг усыг ионгүйжүүлэхэд ашигладаг.

**2.21. Шүүх үйл ажиллагаа**

Хаягдал усан дахь хатуу том бодисуудыг ялгаж зайлуулахын тулд усыг нүх сүв бүхий материал дундуур нэвтрүүлэх.

**2.22. Флотаци**

Хаягдал усан дахь умбуур бодисын жижиг хэсгүүдийг түүний гадаргууд хөвүүлэх үйл ажиллагаа. Жишээ нь: жижиг хэсгүүдийг хийн цэврүүний гадаргууд цуглуулан хөвүүлж болно.

**2.23. Нэвсгэр тунадас**

Тунаж суух болон флотацийн үр дүнд ялгарах, эсвэл флотацийн үр дүнд бий болох макро-жижиг хэсгүүд.

**2.24. Флокуляци**

Жижиг хэсгүүд хоорондоо нэгдэж, ялгаж салгаж болохуйц болдог томоохон хэмжээний хэсгүүд үүсгэх үйл ажиллагаа. Механикийн, физикийн, химийн болоод биологийн арга хэрэглэдэг.

**2.25. Фторжуулалт**

Фторт нэгдлийн ионы концентрацийг тогтоосон хязгаарын дотор хадгалж байхын тулд ундааны усанд фтор агуулсан химийн бодис нэмж өгөх.

**2.26. Ион солилцол**

Ион солилцогч материалын (2.26.1) үе давхаргын дундуур усыг нэвтрүүлэхэд усанд агуулагдаж байгаа анион буюу катионууд өөр бусад ионуудаар халагдаж солигдох үйл ажиллагааг хэлнэ.

**2.26.1. Ион солилцлын материал**

өөрийнхөө бүтцэд өөрчлөлт оруулалгүйгээр анхны байдалдаа эргэж орох боломжтой байдлаар ионуудаа харьцаж буй шингэнтэйгээ солилцох чадвартай материал.

**2.26.2. Холимог үе давхарга (ион солилцол)**

анион ба катион солилцох чадвартай материалуудын (нэг төрлийн) механик (физик) хольцийг хэлнэ.

**2.26.3. Регенераци**

ион солилцогч материалыг тухайн зориулалтаар ашигласны эцэст түүнийг дахин хэрэглэж болох төлөв байдалд нь буцаж орох үйл ажиллагаа.

**2.27. Нитритжүүлэлт**

аммонийн нэгдлийг нянгаар исэлдүүлэх үйл ажиллагаа.

ТАЙЛБАР: энэхүү исэлдэх үйл ажиллагаагийн завсарын бүтээгдэхүүн нь нитрит байдаг ба эцсийн бүтээгдэхүүн нь нитрат байна.

**2.28. Исэлдүүлэгч цөөрөм**

хурдавчилсан байгалийн буюу зохиомол аргын тусламжтайгаар агаар дахь хүчилтөрөгчийг усанд уусгах замаар түүнд байгаа органик бодисуудыг биологийн аргаар исэлдүүлэхэд зориулагдсан, хаягдал усыг зайлуулахын өмнө түүнийг хэсэг хугацаанд хуримтуулан байлгадаг бохир усны сан.

**2.29. Озонжуулалт**

ус буюу хаягдал усанд озон нэмж өгөх замаар ариутгах, органик бодисыг исэлдүүлэх, мөн усны эвгүй амт ба үнэрийг арилгах зорилгоор хэрэглэх.

**2.30. Перколяцийн шүүлтүүр**

биологийн шүүлтүүр (2.8) гэснийг үз

**2.31. Полиэлектролит**

ионжсон бүлгүүд агуулсан полимерүүдийг хэлнэ. Тэдгээр зарим төрлийг усан дахь коллоид жижиг хэсгүүдийг коагуляцид оруулах эсвэл умбуур жижиг хэсгүүдийг флокуляцид оруулах зорилгоор ашиглана.

**2.32. Урьдчилсан хлоржуулалт**

усан дахь ургамал болон амьд биетний бактерийн өсөлт хөгжилтийг бүрмөсөн зогсоох буюу мэдэгдэхүйц хэмжээгээр удаашруулах, органик ба органик бус бодисыг исэлдүүлэх, флокуляцийн үйл ажиллагаа дэмжлэг үзүүлэх, үнэрийг дарах зорилгоор түүхий усыг хлороор урьдчилан цэвэршүүлэх.

**2.33. Эсрэг осмос**

уусмалуудын осмос даралтын ялгавраас давсан хэмжээний даралтын үйлчлэлийг концентраци ихтэй уусмалаас концентраци багатай уусмалд хагас дамжуулагч хальсны (мембран) дундуур ус нэвтрүүлэх үйл ажиллагаа.

**2.34. Тунгаах үйл ажиллагаа**

ус буюу хаягдал усанд агуулагдаж байгаа умбуур бодисуудыг хүндийн хүчний үйлчлэлийн нөлөөгөөр тунгаах, хурдас үүсгэх үйл ажиллагаа.

## **MNS ISO 6107-1 :2002**

### **2.35. Өөрөө цэвэрших**

бохирдсон ус байгалийн нөхцлөөр өөрөө аяндаа цэвэрших үйл ажиллагаа.

### **2.36. Тунгаах сан**

урсан ирж байгаа бохир усыг агааргүй нөхцөлд нянгийн үйлчлэлээр тунасан жижиг хэсгүүдийг задладаг агааржуулагчтай битүү лаг тунгаах зориулалттай сан.

ТАЙЛБАР: ийм замаар тунгаах санг үе үе хоосолж, тундас, лагийг зайлуулах давтамжийн тоог цөөрүүлнэ.

### **2.37. Усыг зөөлрүүлэх**

усны хатуулаг чанарыг нэмэгдүүлдэг кальци ба магнийн ионуудыг уснаас бүрэн буюу тодорхой хэсэгчлэн зайлуулах үйл ажиллагаа.

### **2.38. Ариутгал**

усан дахь бүхий л амьд организм улирлын чанартай эсвэл тодорхой хугацаанд үрждэг амьтан ургамал, нянгуудыг устгаж ариутгал хийх үйл ажиллагаа.

**2.39.** биологийн шүүлтүүр (2.8) гэснийг үз.

## **2.40. Лагийн боловсруулалт**

### **2.40.1. Усгүйжүүлэх**

нойтон лагийг коагуляцид оруулах, эсвэл физикийн арга ашиглан түүн дэхь усны агууламжийг багасгах үйл ажиллагаа.

#### **2.40.1.1. Центрифугийн арга**

хаягдал усны лаганд агуулагдаж байгаа усыг нь төвөөс зугатаах хүчийг ашиглан тодорхой хэмжээгээр зайлуулж бууруулах.

#### **2.40.1.2. Өтгөрүүлэлт**

лаг дахь усыг зайлуулах замаар түүнд агуулагдаж байгаа хатуу бодисын концентрацийг нэмэгдүүлэх үйл ажиллагаа.

### **2.40.2. Тогтворжуулах**

Агааргүй орчинд явагдах биологийн үйл ажиллагааны үр дүнд лаг дахь органик бодисыг тогтворжуулах үйл ажиллагаа.

**ТӨГСӨВ.**



## Цагаан толгойн дэс дарааллаар байрлуулсан үгийн хэлхээс

А	
Аадар борооны ус	1.1.10
Аадар борооны урсац	1.1.11
Агааргүй төлөв байдал	2.6
Агааргүйжүүлэлт	2.10
Агааржуулалт	2.4
Агааржуулсан төлөв байдал	2.5
Ахуйн хаягдал ус	1.2.5
Б	
Биологийн шүүлтүүр	2.8
Бойлорын ус	1.4.2
Боловсруулалт хийгдээгүй ус	1.1.9
Борооны ус	1.1.8
Г	
Гадаргуугын ус	1.1.13
Гипертроф ус	1.1.4
Гиполимнион	1.1.5
Д	
давсгүйжүүлэлт	2.17
Детрит	1.2.2
Дигержүүлэх	2.40.2
Ё	
Ёроолын тунадас	1.2.1
И	
Идэвхжүүлсэн лагаар цэвэршүүлэх	2.1
Идэвхит лаг	1.2.6.1
Ионгүйжүүлэлт	2.13
Ионсолилцол	2.26
Ионсолилцдог материал	2.26.1
Исэлдүүлэгч цөөрөм	2.28
Л	
Лаг (шавар)	1.2.6
Лагийн боловсруулалт	2.40
Н	
Нитрагүйжүүлэлт	2.15
Нитржүүлэлт	2.27
Нэвсгэр тунадас	2.23
Нэрэлт	2.19
О	
Озонжуулалт	2.29
Олиготроф ус	1.1.6
Ө	
Өөрөө цэвэрших	2.35
Өтгөрүүлэлт	2.40.1.2
П	
Перколяц шүүлтүүр	2.30
Полисапроб ус	1.2.7
Полиэлектролит	2.31

## MNS ISO 6107-1 :2002

Р	
Регенараци	2.26.3
С	
Стратификаци	1.1.12
Т	
Термоклин	1.1.14
Тунгаах	2.34
У	
Ундны ус	1.3.1
Ус зайлуулалт	1.2.3
Усгүйжүүлэх	2.40.1
Усны чанарын үнэлгээний хэмжүүрүүд	1.5.1
Усыг зөөлрүүлэх	2.37
Усны чанарын стандарт	1.5.2
Урьдчилсан хлоржуулалт	2.32
Усны чанартай холбоотой нэр томъёо	1.5
Ү	
Үйлдвэрийн хаягдал ус	1.2.4
Үйлдвэрийн ус	1.4.1
Ф	
Ферментэт үе давхарга	2.7
Физик-химийн боловсруулалт	2.3
Флокуляци	2.24
Флотаци	2.22
Фторжуулалт	2.25
Х	
Халдваргүйжүүлэх	2.18; 2.38
Халдваргүйжүүлэх сан	2.36
Хаягдал ус	1.2
Химийн цэвэршүүлэлт	2.2
Химийн коагуляци	2.9
Хотын цэвэрлэгдсэн ус	1.2.5.2
Хотын цэвэрлэгдээгүй хаягдал ус	1.2.5.1
Хотын хаягдал усыг зайлуулах	1.2.5.3
Хөргөлтийн ус	1.4.3
Хлоргүйжүүлэлт	2.11
Хийгүйжүүлэлт	2.12
Хүчилтөрөгчийг зайлуулах	2.16
Хүн амыг ундааны усаар хангахад зориулагдсан ус	1.3.2
Холимог үе давхарга	2.26.2
Ц	
Цахилгаан диализ	2.20
Центрафугийн арга	2.40.1.1
Ш	
Шүүх үйл ажиллагаа	2.21
Э	
Эвтроф ус	1.1.2
Эрдэсжүүлэлт	2.14
Эсрэг осмос	2.33
Эпилимион	1.1.1